



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№158 /372/

2022.09.08

Цаг үе, үйл явдал

ЯПОНЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР “ЗАМ” СУРГАЛТ, ДАДЛАГЫГ ОНЦОЛЖЭЭ

Япон Улсын Батлан хамгаалах яамны цахим сайт болон тус орны хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хоёр улсын Зэвсэгт хүчний хамтарсан “Зам” сургалт, дадлагын талаар онцолжээ. Мэдээлэлд “2014 онд Япон Улсын БХЯ болон Япон Улсын өөрийгөө хамгаалах хүчнээс Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг зам барилгын салбарт сургахад хувь нэмэр оруулах болон НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд инженерийн ангиудыг оролцуулахад шаардагдах ур чадварын нэмэгдүүлэх ажлын хүрээнд энэхүү төслийг эхлүүлсэн.

2021 оноос Япон Улсын БХЯ болон Япон Улсын өөрийгөө хамгаалах хүчнээс тус сургуулийн 3 дахь үе шатыг эхлүүлсэн ба товч дурдахад энэхүү сургалтын 1-р үе шатыг 2014-2016 онд замын ажлын үндсэн сургалт, 2-р үе шат буюу 2017-2019 онд замын ажлын гүнзгийрүүлсэн сургалтыг замын ажлын машин, техникүүд дээр ажиллах, замын хажуугийн ус зайлуулах хоолойг хийх бүх төрлийн хэмжилт, тооцоо өгөгдөхүүнүүд дээр ажиллах сургалт, дадлагыг зохион байгуулж явуулаад байна.

Тэгвэл энэ удаагийн 3 дахь шатны хамтарсан сургалтаар Монгол Улсын зэвсэгт хүчний инженерийн цэргүүд өөрсдөө бие дааж зам барилгын ажлыг төлөвлөж сурах чадвартай боловсон хүчнийг бэлтгэх ажлын хүрээнд Япон Улсын өөрийгөө хамгаалах хүчний сургагч багш нар Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн цэргийн сургагч нар болон суралцагч нарыг зам барилгын ажилд сургахаас гадна техникүүд дээр ажиллах заавар зөвлөгөөг өгч ажилласан.



Түүнчлэн “Зам-2022” сургалтад АНУ-аас Монгол Улсын харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож байна. Энэхүү сургалтыг зохион байгуулснаар Монголын Улстай Батлан хамгаалах салбарын харилцаагаа ахиулж, туршлага, мэдлэгээ хуваалцах боломжийг бүрдүүлснээр хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байгаагаараа онцлог болж байна” гэжээ.

Энэ жил Япон, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож байна. Энэхүү сургалтыг зохион байгуулснаар Монголын Улстай Батлан хамгаалах салбарын харилцаагаа ахиулж, туршлага, мэдлэгээ хуваалцах боломжийг бүрдүүлснээр хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байгаагаараа онцлог болж байна” гэжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.193.00	3.198.0
EUR 🇪🇺	3.263.0	3.280.0
CNY 🇨🇳	474.00	477.00
RUB 🇷🇺	48.50	49.50
JPY 🇯🇵	23.75	24.00
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.09.08 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 4

**ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ
САРЫН ЗУРГААН ЦАГААН
УЛААН НОХОЙ ӨДӨР**

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна.
Наран ургах, шингэх:
05.28-20.29
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Сансар
Суудал: Төмөр

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XV ЗУНЫ НААДАМ БОЛНО

Монголын бүх ард түмний спортын XV зуны наадмын нээлт маргааш болох гэж байна.

Тус наадам 9 дүгээр сарын 19 хүртэл Улаанбаатар хотноо болж, 21 аймаг, 9 дүүргийн 4500 гаруй баг тамирчин 561 багц медалийн төлөө өрсөлдөх ажээ. Наадамд олимпын 20 төрөл, паралимпын 3 төрөл, дифлимпын 2 нийт 25 спортын төрлөөр зохион байгуулагдана.

Зэвсэгт хүчин, Онцгой байдал, Хууль сахиулах байгууллагын спорт хороо, спортын клубууд нь 202 багц медалийн төлөө өрсөлдөх юм.

Батлан хамгаалах яамны “Алдар” спорт хорооны хувьд 13 спортын төрлөөр энэхүү наадамд оролцоно.

Өнөөдрийн байдлаар наадмын пауэрлифтинг, байт харваа, жүдо бөхийн төрөл зохион байгуулагдаад байна. “Алдар” спорт хороо нь жүдо бөх, байт харвааны төрөлд оролцож, 9 алт, 1 мөнгө, 7 хүрэл медаль хүртээд байна.

Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, Олимпын шигшээ багуудыг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Наадмын хаалтын арга хэмжээний үеэр спортын 26 төрлөөр медалийн чанараар эхний 6 аймаг, 3 дүүрэг, Зэвсэгт хүчин, Онцгой байдал, Хууль сахиулах байгууллагуудын дэргэдэх спортын хороод, клуб, шигшээ тэмцээнийг сайн зохион байгуулсан 5 спортын холбоог тус тус шалгаруулах юм байна.

Мөн шигшээ тэмцээний алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тамирчин, багийн дасгалжуулагчийг Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу алтан медаль 1.5 сая төгрөг, мөнгөн медальд 1 сая төгрөг, хүрэл медальд 500 мянган төгрөгийн мөнгөн шагналыг олгох ажээ.



Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 582,373,933

Эдгэрсэн

Нийт: 552,651,454

Нас барсан

Нийт: 6,419,951

Цахим шууданд

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГҮҮД БҮТЭЭН БАЙГУУЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын байрны гадаад үзэмжийг сайжруулах, бие бүрэлдэхүүн болон албан ажлаар ирдэг зочид төлөөлөгчдөд аятай тухтай орчин бүрдүүлэх хүрээнд авто машины зогсоол, түүний эргэн тойрны ногоон байгууламжийг стандартын дагуу тохижуулах ажил явагдаж байна. Бүтээн байгуулалтыг Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн барилгачин дайчид гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 85 хувьтай явагдаж байна.

АР ТАЛЫНХАН СПОРТООР ӨРСӨЛДӨЖ БАЙНА



ЗХЖШ Материал, Техникийн газрын харьяа анги байгууллагуудын дунд зохин байгуулагддаг спортын уламжлалт тэмцээн "Ар Тал-2022" эхэллээ. Цар тахлын улмаас 2017 оноос хойш завсарлаад байсан уг тэмцээн нь хоёр жил тутам зохион байгуулагддаг төдийгүй 13 дах жилдээ сагсан бөмбөгийн тэмцээнээр нээлтээ хийлээ. Нийт 11 анги, салбарын залуус сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, үндэсний бөх гэсэн таван төрлөөр баг тамирчид өрсөлдөж хурд хүчээ сорьж байна. Зэвсэгт хүчний ар талын албанд хүчин зүтгэдэг анги, салбарын бие бүрэлдэхүүн спортын өрсөлдөөнөөр хоорондоо нөхөрлөж, хамт олонч уур амьсгал бүрдүүлэх, алба хаагчдын бие бялдрын хөгжил эрч хүчийг сэлбэх зорилгоор уг тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулдаг ажээ.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2023-2024 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан, цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтыг 2022 оны 09 дүгээр сарын 26-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид:

2021 онд батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ" –тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт
3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
4. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
5. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь.
6. Товч судалгаа
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт

Анги	Албан тушаал	Цол	Овог, нэр	Нас	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон огноо	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 88002650, 92096622-тэй холбогдож тодруулах/ "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ" –тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmaf.gov.mn/gsmaf/cat/60> холбоосоор, англи хэлний бичгийн болон ярианы шалгалтын сэдвүүдтэй <https://gsmaf.gov.mn/gsmaf/onePost/2220> холбоосоор орж танилцана уу. Эмэгтэй цэргийн алба хаагчдыг өргөнөөр оролцохыг урьж байна.

ЗХЖШ-ЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

МЭЛМИЙ

ХОЁР ӨДӨР ГУРВАН ЭМЧИД ҮЗҮҮЛСЭН НЬ

Нүд өглөө босоход улаан болжээ. Эмийн санд очоод нүдний эм авах гэтэл "Таны насны хүмүүст эмчийн бичгээр л өгнө" гэлээ. Аргагүй мэргэжлийн ёс зүйтэй хүний үг. Ингээд госпиталийн залуу эмч их л хичээнгүй үзэж үзэж, нүдэнд шинээр судас ургаад хагарсан байна, хяналтад орох хэрэгтэй гээд "Болор мэлмий" рүү утсаар ярьж өглөө. Өглөө нь таньдаг хүнээр хэлүүлж Төмөр замын эмнэлгээр ороод дөч гарсан бүсгүй (туршлагатай гэсэн үг) Ургамалцэцэг эмчид үзүүлбэл "нүдний уг зүгээр" гээд эм бичиж өглөө. Энэ мэдээг сонсоод харааны асуудалтай боллоо гэж бодож байсан минь арай тайвширч гэхдээ хувийн эмнэлгээр үйлчлүүлж баталгаажуулъя гэж шийдлээ.

Өмнө нь үнэгүй үзлэгүүд хийсэн бол хувийн эмнэлэгт 35000 төгрөгөөр үздэг юм байна. Өрөө тасалгааны зохион байгуулалт, байр тоног төхөөрөмж нь үнэ өртөгтөө таарсан бололтой. Эмч нар нь залуухан, Баясаа эмч гэхэд Японд мэргэжил дээшлүүлсэн бол зарим эмч нар тав, зургаан удаа Герман, Солонгос, Турк, Энэтхэг улсуудад нарийн мэргэжлээр сурсан танилцуулгаа үүдэндээ өлгөжээ. Нэг зэрэг 50-60 хүнд ерөнхий үзлэг хийгээд дараа нь нарийн үзлэгийн дөрвөн өрөөнд 1-2 эмч үзэж, зөвлөгөө өгдөг юм байна. Хариу нь Ургамал эмчтэй адил гарч сэтгэл амраав. Хоёрхон эмчид үзүүлсэн бол алинд нь итгэхээ мэдэхгүй болох байлаа.

Манай цэргийн госпитальд миний мэдэхийн С.Балгансүрэн, Л.Баясгалан, А.Даваасамбуу, С.Юндэн, Р.Даваадорж, Зориг, Батболд нарын дарга нар ажиллаж байлаа. Балгансүрэн эмч яамны сайд, дарга нартай үгээ ололцдог, зиндаа өндөр дарга байсан бол армийн анхны энхийг сахиулагч Р.Даваадорж энхийг сахиулах хоёрдугаар шатны эмнэлгийг НҮБ-д үүрэг гүйцэтгүүлэх бэлтгэлийг хариуцан ажиллаж байсан түүхтэй.

Эрүүл мэндийн сайд байсан дэд хурандаа Зориг

дарга госпиталийг шинэ байр, орчин үеийн тоног төхөөрөмжтэй болгох хир баргийн сайд ч хийж чадахгүй ажлыг ёстой зоригоороо хийж дөнгөсөн буянтандаа. Зориг иргэний зориг гаргаж госпиталийн эмч нарыг буу, мэсний шархыг эмчилдэг, дүүргийн эмнэлгийн ачааллыг хуваалцдаг үүрэгтэй болгож байсан. Одоо бие нь тааруухан гэсэн госпиталийн хананд нэр нь байх ёстойг яамны удирдлага анхаарна биз.

Батболд госпиталийг удирддаг байхдаа энхийг сахиулах, дайчилгааны нийтийг хамарсан өвчлөлийн үеийн бэлэн байдлыг хангах тал дээр санаачилгатай анхааран ажиллаж байсан нь цар тахлын үед госпиталь улсын Халдвартын ачааллын талыг заримдаа ихэнхийг өөртөө хүлээж авч ажиллах боломжийг хангаж, гурван хүн эмнэлгийн гавьяат боллоо. Ялангуяа Ковидын үед госпиталийн залуу эмч нар их туршлага сууж, цэргийн албанд суралцлаа хэмээн ахмадууд нь үнэлж байна лээ.

Госпиталийн мэс заслын Ч.Балдир, Л.Жамбалжав, мэдрэлийн Х.Должин, дотрын П.Намсрай, Мэндсайхан, Тунгаамаа гээд олон сайхан эмч нартай үе байсан. Багшийн маань эхнэр Намсрай эмч манайд нэг төө хиртэй олс бариад орж ирснээ "Үүнийг анагаахад сурч байхад буруу байрлалтай мухар олгойг илрүүлэхэд ашигла гэж зааж байсан юм, одоо ч мэдэх хүн цөөрчээ" гэж байж билээ. Тэгээд хүүхдийн эмнэлэг оношилж чадахгүй 7 хоног гэдэсний эм уулгасан хүүг маань Намсрай эмч зөв оношилж, яаралтай хагалгаанд оруулснаар мухар олгойг нь эгзэгтэй мөчид нь авч байсан түүхтэй.

Эмч хүн дөч хүрээд алдахаасаа (алахаасаа) аврах нь илүү болж, мэдлэг

туршлага жигдэрч ирдэг гэж ярьдаг даа. Ямар сайндаа л "Жор үзсэн эмчээс зовлон үзсэн эмгэн дээр" гэж ярихав Иймд эмч, багш, эрдэмтдийг залуугаар нь ялангуяа госпиталийн эмч нарыг 40 гарангуут тэтгэвэрт гаргадаг нь буруу болохыг яамны газрын дарга байхдаа ойлгож тэднийг үргэлжлүүлэн ажиллуулах



шинэ журам санаачлан гаргаж байсан ч амьдрал дээр сайн хэрэгжээгүй л байгаа бололтой. Тухайн мэргэжлээр тэргүүлэх зэрэгтэй эмч гэх зэргээр ажилласан жил, чадвараар нь зэрэг тогтоож эмч нарыг мэргэшүүлдэг болсон. Гэтэл цэргийн байгууллага учир эрт тэтгэвэрт гардагаас сайн эмч нартай болж чадахгүй байгаа гэж хүмүүс ярьдаг. Саяхнаас эмнэлгийн залуухан дарга Б.Энх –Од Жаргалсайхан, Жамбалжав, Гүржав нарыг зөвлөх эмчээр ажиллуулах болсон байна лээ.

Эцэст нь хүн нүдээрээ алаг дэлхийгээ тольдон амьдрах нь ямар их баяр баясгалан болохыг мэдрүүлж, сэрэмж өгсөн госпиталийн залуу эмч, туршлагатай эмч Ургамалцэцэг, ирээдүйтэй залуу эмч Баясаа нар болон госпиталийн эмч, сувиллагч нартаа баярласнаа илэрхийлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн салбарын ялангуяа цэргийн госпиталийн талаар илүү, дутуу зүйл ярьсандаа хүлцэл өчье.

(Ph.D) доктор, бэлтгэл бригадын генерал Ч.СОСОРБАРАМ

Гэрэл зураг нэг-агшин

